

Гарчиг

- 1. Эрхэм зорилго**
- 2. Бидний уриа**
- 3. Хэтийн төлөв**
- 4. Сурагч элсүүлэх журам**
- 5. Суралцагч нь тухайн сургуулиас шилжихдээ**
- 6. Дүн үнэлгээ**
 - 6.1 Түвшин тогтоох үнэлгээ
 - 6.2 Явцын үнэлгээ
 - 6.3 Нэгтгэн дүгнэх буюу эцсийн үнэлгээ
 - 6.4 Анги дэвшин суралцахад дараах зүйлс нөлөөлнө
- 7. Сургалтын бүхий л түвшинд тавигдах шаардлага**
 - 7.1 Монгол-Од сургуулийн сурагчдын зорилго
- 8. Сурагчийн ёс зүйн хэм хэмжээ**
 - 8.1 Сурагчийн сахилга батын хэм хэмжээ
 - 8.2 Сурагчид дараах журмыг хатуу мөрдөх ёстой
 - 8.3 Сахилга бат зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээ
 - 8.4 Дараах тохиолдолд сурагчийг нэн даруй сургуулиас түтгэлзүүлнэ
 - 8.5 Сурагчийг сургуулиас хасах
- 9. Хичээлийн ирц хоцролтын талаарх бодлого**
 - 9.1 Хичээл таслалт
 - 9.2 Урьдчилан чөлөө авах
- 10. Сургуулийн орчинд эцэг эхийн харилцаа**
- 11. Эцэг эхийн оролцоо**
- 12. Гар утас болон бусад электрон хэрэгслүүд**
- 13. Тэмдэглэлт баяр**
 - 13.1. Тэмдэглэлт баяр зохион байгуулах дүрэм журам
 - 13.2. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд
- 14. Сурагчдын аялал**
- 15. Хүүхдэд чиглэсэн сурх орчин**

16. Хүүхдээ амжилттай суралцахад нь хэрхэн туслах талаар

17. Бие даалт, гэрийн даалгавар

17.1 Гэрийн даалгавар

17.2 Гэрийн даалгавар хийхэд эцэг эх оролцсоноор

17.3 Сурагчдын бие даан гэрийн даалгавар гүйцэтгэх хугацаа

17.4 Багшийн үүрэг хариуцлага

17.5 Сурагчийн үүрэг хариуцлага

17.6 Эцэг Эцэг эхийн үүрэг хариуцлага

18. Дүрэмт хувцас

18.1 Бага анги /1-5/

18.2 Дунд анги /6-8/

18.3 Сурагчид дүрэмт хувцсаа өмсөхөөс гадна дараах журмыг даган мөрдөнө

18.4 Гутал

18.5 Yc

18.6 Гоёл чимэглэл

19. Биеийн тамирын хувцас

19.1 Биеийн тамирын хичээлд тавигдах шаардлага, тусгай мэдээлэл

19.2 Тохиромжтой хувцас

19.3 Үнэт эдлэл

19.4 Yc

19.5 Өвчин, гэмтэл

20 Дунд ангийн суралцагчдын талаарх эцэг эх багшийн харилцах дэвтэр

21 Сургалтын төлбөр

22 Хичээлийн дараах дугуйлан буюу сонгон суралцах хичээл

23 Сурагчийн зөвлөл

23.1 Эрхэм зорилго

23.2 Үйл ажиллагааны үндсэн чиглэл

23.3 Сурагчийн зөвлөлийн бүрэлдэхүүн

23.4 Зөвлөх багшийн үүрэг

24 Сурагчдын Автобусны Үйлчилгээ

- 24.1 Автобусны чиглэлүүд
- 24.2 Сургуулийн автобусны ирэх, явах цаг

25 Номын сан

- 25.1 Сургуулийн номын сангийн зорилго
- 25.2 Номын сангийн журам

26 Хичээлийн хэрэгсэл ба ном


- 27 Сурагчдын өдрийн хоолны цэс**
- 28 Кино үзвэрийн өрөө ашиглах журам**
- 29 Ширээний теннисний өрөө ашиглах журам**
- 30 Компьютерийн өрөө ашиглах журам**
- 31 Сурагчийн шүүгээ ашиглах**
- 32 Өвдөх**
- 33 Эмийн хэрэглээ**
- 34 Яаралтай үед эцэг эхтэй холбоо барих**
- 35 Хичээлээс гадуурх нэмэлт цаг, таралт**
- 36 Хүндэт эцэг эхчүүдээ!**

1. Эрхэм зорилго

Монгол-Од сургууль нь 2011 онд байгуулагдсан бөгөөд бид өнөөг хүртэл сурагчдыг сургалтын таатай орчноор хангаж, орчин үеийн заах арга барил болон англи хэлний эрчимжүүлсэн сургалтад тулгуурлан үйл ажиллагаагаа явуулдаг. Бидний зорилго бол дэлхийн иргэн буюу өөрийн эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарласан иргэн төлөвшүүлэн бэлтгэж, Монгол-Америкийн сургалтын хөтөлбөрт хийсэн харьцуулалтын дагуу чанартай боловсрол олгоход оршдог билээ. Бид Америкийн боловсролын стандарт, сургалтын арга технологийг Монгол сурагчдын онцлогт тулгуурлан нэвтрүүлсээр байна.

2. Бидний уриа

Shine like a star /Од шиг гялалзана/



3. Хэтийн төлөв

Бид суралцагчдынхаа оюун ухаан бие бялдрын хөгжилд нас насанд нь онцгойлон анхаарч тэдний авьяас чадварыг илрүүлэн өв тэгш хөгжүүлэх тал дээр ажиллана. Англи хэлийг нэгдүгээр ангиасаа эхлэн суралцсанаар ахисан түвшин хүртэл гүнзгийрүүлэн суралцаад зогсохгүй цаашлаад академик түвшинд хүртэл суралцах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн сургалтуудаа улам чанаржуулах.

4. Шинээр элсэн суралцагчийн мөрдөх журам

Монгол – Од сургуулийг сонгон шинээр элсэн суралцахдаа

- Суралцагчийн эцэг эх сургалтын албатай уулзана
- Сургалтын албанаас тухайн сурагчаас түвшин тогтоох шалгалт авч дүгнэнэ
- 70% -аас дээш үнэлгээ авсан суралцагч тухайн сургуулийн сонгосон ангидаа элсэн суралцана.
- 70% -аас доош оноо авсан бол тухайн элсэн суралцах ангийн багштай уулзаж мөн шалгалтад хамрагдана.
- Хэрэв зохих оноондоо хүрээгүй бол сургуулийн захиргаанаас хоцрогдол арилгах нэмэлт давтлаганд суралцахыг санал болгоно/7 хоногт 2-3 удаа 12 цагийн давтлагыг 80 000 төгрөгөөр суралцах боломжтой/.
- Шинэ суралцагч нь элсэн суралцахаар бол өмнө суралцаж байсан сургуулийн цахим бүртгэлээс хасалт хийлгэн хувийн хэргээ авч ирж манай сургуулийн сургалтын цахим бүртгэлд бүртгүүлнэ /Хувийн хэргийн бичилт, тамга тэмдгийг өмнөх сургуулиасаа авахдаа шалгаж авч ирэх/.
- Сургуулийн захиргаа, анги удирдсан багш, эцэг эхийн хамтын гэрээ байгуулна.

5. Суралцагч нь тухайн сургуулиас шилжихдээ:

Өөрийн хүсэлтээр гарагыг хүсвэл дараах зүйлсийг анхаарах шаардлагатай

- Юунаас болоод сургуулиас гарч байгаагаа тодорхой бичсэн өргөдөл бичиж сургуулийн захиргаанд өгч гэрээг цуцална
- Сургалтын төлбөр тооцоог сургуулийн санхүүгийн албатай тооцоо хийнэ.
- Дууссан тохиолдолд сургуулийн захиргаатай уулзан хувийн хэрэг болон цахим бүртгэлээс хасалт хийлгэнэ.
- Хичээлийн жилийн дундуур шилжсэн тохиолдолд ангийн багш болон сургуулиас өмнөх улиралд суусан хичээлийн дүнг авна.
- Тухайн ангийн багштай уулзаж хичээлийн ном сурх бичиг болон бусад тооцоог дуусгавар болгож гарын үсэг зуруулна.

6. Дүн үнэлгээ

Монгол-Од сургууль нь сурагчийн мэдлэгийг түвшин тогтоох, хичээлийн явцын, нэгтгэн дүгнэх буюу эцсийн гэсэн 3 байдлаар үнэлэн дүгнэдэг.

6.1. Түвшин тогтоох үнэлгээ: Аливаа сургалт, бүлэг сэдэв судлахын өмнө сурагчдын суурь болон өмнөх мэдлэгийг шалган тодорхойлох хэрэгтэй болдог. Мөн энэ нь багшид сурагчдын цаашдын сурх үйл ажиллагааг өргөтгөх, идэвхжүүлэх арга замыг тодорхойлоход нь тусална. Энэ аргаар Монгол-Од сургууль шинээр элсэн орж буй сурагчдыг үнэлж дүгнэж түвшинг тогтоодог.

6.2. Явцын үнэлгээ: Энэхүү үнэлгээ нь сурх, сургах үйл явцыг сайжруулах зорилгоор хийгдэж буй үргэлжилсэн үйл явц юм. Явцын үнэлгээ нь сурагч, багш, эцэг эхчүүдэд тухайн сурагчийн сурх явцын талаар цаг тухайд нь мэдээллэх, цаашид илүү сайн сургахын тулд хэрхэн яах ёстойг дүгнэн цэгнэхэд чухал ач холбогдолтой.

6.3. Нэгтгэн дүгнэх буюу эцсийн үнэлгээ: Энэ үнэлгээ нь бүлэг сэдэв судалж дууссаны дараа сурагчдын сурсан мэдсэнийг бататган дүгнэхэд хэрэглэгддэг бөгөөд мөн сурагчдын сурлагын амжилтыг тодорхойлдог.

Жич: Монгол – Од сургуулийн захиргаанаас улирал тус бүрийн эцэст сурагчдын нэрийг кодлон түвшин тогтоох шалгалт авч үнэлж дүгнэдэг. Иймд эцэг эхчүүд хүүхдийнхээ нэрний кодыг мэдэж, дүн үнэлгээтэй нь танилцаж байх хэрэгтэй.

6.4. Анги дэвшин суралцахад дараах зүйлс нөлөөлнө:

- Хичээлийн ирц болон цаг барьдаг байх.
- Хөтөлбөрийн дагуу стандартын түвшинд хүрсэн байх
- Ангийн багш сурлагын эрсдэлд орсон хүүхдийн талаар сургалт хариуцсан захиралд мэдэгдэж, эцэг эхтэй уулзаж, зохих арга замыг шийдвэрлэнэ.

Сургуулийн захиргаа, эцэг эх, багш нар тухайн хүүхдийн анги дэвшин суралцах аль эсвэл давтан суралцах эсэхийг зөвлөлдөнө

7. Сурагчийн эрхэмлэх зүйлс

7.1. Монгол-Од сургуулийн сурагчдын зорилго

Дэлхийн иргэн бэлтгэх стандартын дагуу төлөвшиж өөрийн эрх, үүрэг, хариуцлагыг ухамсарласан хариуцлагатай иргэн болох.

Суралцагч нь:

Сурч боловсрохыг эрмэлзэгч байх

- Олж авсан мэдлэг, мэдээлэлдээ тулгуурлан өөрийн зорилгыг ухамсартайгаар тодорхойлж сурах ба өөрөө идэвхтэй сурч боловсрох
- Сайн суралцахын тулд өөртөө байнга хяналт тавьж үнэлгээ, дүгнэлт өгөх

Бүтээлчээр сэтгэгч байх

- Асуудлыг тунгаан бодох, шийдвэр гаргах, зөрчилдөөнийг зохицуулах чадвартай байх
- Мэдлэгээ амьдралдаа хэрэгжүүлдэг байх

Нийгэмд идэвхтэй иргэн байх

- Хүрээлэн буй орчин, хамт олондоо санаа тавьж сурах
- Өөр соёл иргэншилтэй хүмүүсийг хүндэтгэн үзэж, хамтран ажиллах чадвартай болох
- Бусдын эрх ашгийг хүндэтгэдэг байх
- Өөрийн болон бусдын аюулгүй байдал, эрүүл мэндэд анхаарал тавьдаг байх

Харилцааны өндөр чадвартай байх

- Аливаа хэрэгслэлээс олж авсан мэдээллийг уншиж, бичиж, сонсож ойлгож сурах, түүнийгээ дамжуулах чадвартай байх
- Техник технологийг үр дүнтэй ашигладаг байх
- Ойлгох, эрэгцүүлэх бодох чадвараа сайжруулахын тулд бусдыг анхааралтай сонсож, асуулт тавьж сурах
- Сургуулийн орчинд бусадтай хүндэтгэлтэй зөв боловсон харилцах
- Өөрийгөө танилцуулж ойлгуулах чадвар
- Хэн нэгнээс тусламж хүсэх чадвар
- Аливаа юмны зааврыг дагах
- Аливаа нэг юмнаас хазайхгүй түүнд төвлөрөх чадвар
- Дургүйцлээ зөв илэрхийлэх
- Үгүй гэдгээ зөв ойлгуулах
- Баярласан сэтгэлээ зөв илэрхийлэх
- Хэн нэгнээс уучлалт хүсэж сурах
- Өөрийнхөө сэтгэл хөдлөлийг зөв барьж сурах
- Аливаа зүйлийн үр дагаврыг ойлгож сурах

Амьдралын турш өөрийгөө дайчлагч, сэтгэгч байх

- Сурч боловсрох үүрэг, хариуцлагаа ойлгож ухамсарлах
- Сурах зорилгоо тодорхойлж, дэс дараатай хөгжүүлэх, шинэчилж өөрчлөх чадвартай байх
- Өөрийгөө хөгжүүлэх, сорих, шинэ боломжуудыг эрэлхийлдэг байх
- Зорилгоо тодорхойлох, цагаа зөв төлөвлөх, хувийн зохион байгуулалтаараа өрсөлдөх чадвартай байх

8. Сурагчийн ёс зүйн хэм хэмжээ

Монгол – Од сургуулийн хамт олон нь бие биенээ анхаарч халамжилдаг, баҳархах зүйлтэй, сайн сайхан зүйлсийн төлөө тэмүүлдэг уур амьсгалд багш, ажилчид, сурагчид бүгд

хамтдаа суралцаж, өсөж, хөгжиж байх нь чухал юм.

Бид сурагчдаа сургуулийн орчинд чөлөөтэй байлгахыг эрхэмлэдэг боловч бусадтай хүндэтгэлтэй, хариуцлагатай, аюулгүй орчин бүрдүүлэн сахилга батыг сахих шаардлагыг тавьдаг. Энэхүү ёс зүйн хэм хэмжээ нь сурагчдыг дэг журамтай, тодорхой зорилготой болгох нөхцөлийг бүрдүүлж, ирээдүйн манлайлагч иргэн бэлдэхэд чухал ач холбогдолтой.

8.1. Сурагчид дараах хэм хэмжээг мөрдөх ёстой

- 8.1.1. Хичээлийн болон олон нийтийн арга хэмжээнд сургуулиас тогтоосон стандартыг мөрдөх
- 8.1.2. Сургуулиас чиглүүлсэн бодлогыг баримтлах
- 8.1.3. Бусдын болон өөрийн аюулгүй байдлыг эрхэмлэх
- 8.1.4. Соёлын ялгаа, зан үйлийн уламжлалыг хүндэтгэн үзэх
- 8.1.5. Бусдын эд хөрөнгөнд хүндэтгэлтэй хандана.
- 8.1.6. Бусдыг хүндэтгэж, боловсон, соёлтой харьцана.
- 8.1.7. Хоолны зааланд үйлчилсэн ажиллагсад болон тогооч нартаа талархлаа илэрхийлэх
- 8.1.8. Бусад сурагчдыг шоолох, доромжлохыг хатуу хориглоно.
- 8.1.9. Сургуулийн дүрмийн дагуу зөв зохистой хувцаслана.
- 8.1.10. Хичээл, дугуйлан болон сургуулиас зохиогдох бусад арга хэмжээнд цагтаа ирж бэлтгэлтэй оролцно.
- 8.1.11. Сургалтын таатай, аюулгүй орчинг бүрдүүлэхэд шаардлагатай нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээнд биеэ зөв авч явна.
- 8.1.12. Гэрийн даалгавраа хугацаанд нь хийж шалгуулна
- 8.1.13. Багшийн болон хамт олны зөвлөмж, зааврыг хүндэтгэн ажиллана.
- 8.1.14. Хичээлийн цагаар коридороор явахдаа бусдыг хүндэтгэн чимээгүй явна.
- 8.1.15. Сургуулийн шатаар өгсөж, уруудаадаа баруун гарын дүрэм баримталж явна.
- 8.1.16. Ил задгай хог хаяхгүй байх. Зориулалтын хогийн саванд хийнэ.
- 8.1.17. Хичээлийн цагаар дэмий сэлгүүцэхгүй байна.

8.2. Сахилга бат зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээ

Сахилга бат зөрчигдсөн тохиолдолд дараах хэлбэрийн арга хэмжээг авна. Арга хэмжээ нь хүүхдийн хөгжлийн үе шатанд тохирсон байна. Тусгай анхаарал шаардлагатай хүүхдийг

харгалзан үзнэ. Мөн гаргасан алдааны хэмжээг тогтоож, хэдэн удаа давтагдсан, хэр удаан үргэлжилсэн, ямар зорилгоор үйлдсэн зэргийг судалж, харгалзан үзнэ. б шатны арга хэмжээ авна. Үүнд:

1. Анхааруулга өгнө.
2. Ангийн багш эцэг эхтэй уулзалт хийнэ
3. Эцэг эх, ангийн багш, сургуулийн захиргаа хамтарсан уулзалт хийнэ
4. Зарим эрхийг хязгаарлана.
5. Сургууль дээрх хичээлээс тодорхой хугацаагаар түдгэлзүүлнэ.
6. Сургуулиас хасна.

9. Хичээлийн ирц хоцролтын талаарх бодлого

Сурагчийн ирцийг тухайн сурагчийн суралцалтад шууд нөлөөтэй гэж үздэг. Сургуулийн зүгээс шалгалт/даалгаврыг нөхөн үүрэг хариуцлагыг хүлээхгүй бөгөөд багш, сургалтын менежертэй зөвшүүлсөний үндсэн дээр нөхөн авах эсэхийг шийднэ. Хичээлд суугаагүй ямар ч тохиолдолд сурагчаас зохих хичээлийг үзэж мэдлэгтэй болсон эсэх, мэдлэгийн түвшин болон анги дэвших боломжийг тогтоох үүднээс шалгалт авах эрхтэй.

Сурагч хичээлдээ ирээгүй тохиолдол бүрт багш эцэг эхтэй холбогдож, шалтгааныг тогтооно. Хичээлийн ирц сурагчийн амжилттай суралцалтад шууд нөлөө үзүүлдэг учраас эцэг эх хүүхдээ хичээлд нь тогтмол, цагт нь явуулах тал дээр анхаарна. Өглөө 8:30 цагт ангидаа ороогүй сурагчийг хоцорсонд тооцно.

Хичээлийн эхний цаг маш чухал байдаг. Хэрвээ хоцорсон тохиолдолд сургуулийн захиргаанаас сануулах хуудас өгнө. Энэ байдал олон удаа давтагдвал Сургалтын менежер эцэг эхтэй уулзаж асуудлыг шийдвэрлэх талаар ярилцана.

Хичээл тасалдалт үргэлжилж буй тохиолдолд: Сургалт эрхэлсэн захирал эцэг эхтэй ярилцаж, анги улирах болон сургуулиас хасаж болзошгүйг сануулна.

9.1 Хичээл таслалт

Сурагч хичээлдээ ирэх боломжгүй тохиолдолд эцэх эх сургууль руу утасдаж мэдэгдэнэ. Ингэснээр шалтгааныг тогтоож бидний цагийг хэмнэх юм. Эцэг эх сургалтын албанад юмуу багшид утсаар эсвэл цахим хаягаар холбогдож мэдэгдэх боломжтой.

Эцэг эхээс хичээлд суугаагүй шалтгааныг тайлбарласан бичиг авч ирнэ.

- Сурагч өөрөө эсвэл гэр бүлийн гишүүн өвдсөн үед
- Гэр бүлийн гишүүн нас барсан тохиолдолд
- Яаралтай тохиолдолд сурагч чөлөө авч болох бөгөөд эргэж хичээлдээ ирэхдээ эмчийн бичиг авч ирнэ.

Эдгээр тохиолдуудад сургалтын албанаас холбогдох бичиг баримтуудыг бүрдүүлж сургчийн хавтаст хадгална. Хэрэв эмчийн бичиг авч ирээгүй болон сургалтын албаны албан ёсны зөвшөөрөлгүйгээр хичээл тасласан тохиолдолд хүүхдийн сурлагын дүн муудах зэрэг хариуцлагыг сургууль огт хүлээхгүй.

Хичээлээс хүндэтгэх болон хүндэтгэхгүй шалтгаанаар тасалдсан байсан ч багш дахин хичээлийг нөхөн сургах боломж хомс учраас эцэг эхтэй тохиролцон давтлага хичээл бага хэмжээний төлбөртэй авах боломжтой. Энэ талаар сургалтын албандаа заавал мэдэгдэнэ.

9.2. Урьдчилан чөлөө авах

Хүүхдийнхээ аливаа цагийг товлохдоо (жишээ нь: шүдний эмчийн цаг) хичээлийн дараа 14:00 цагаас хойш товлоно уу. Хэрвээ боломжгүй бол ангийн багшид мэдэгдэнэ үү!

Сурагч чөлөө авах шалтгаанаа мэдэж буй тохиолдолд эцэг эхээс бичиг авч ирэн чөлөө авна. Үүнийг албан ёсны чөлөөнд тооцно.

Сургалтын алба сургачийн ирцэнд хяналт тавих ба чөлөө авах хүсэлтийг хүлээн авч чөлөөний хуудсыг бөглүүлнэ. Сурагч хичээл орох багш нараараа гарын үсэг зуруулж сургалтын албандаа авч ирнэ. Чөлөөтэй байх хугацаанд үзсэн хичээлээр сурагчаас шалгалт авна.

Чөлөөний хуудас

Чөлөөний хуудас

..... ангийн сургач-ын /ийн/.....-д
.....шалтгааны
учир сарын өдрөөсөдрийг хүртэл хоногийн чөлөө олгов.
..... –ний өдөр хичээлд бэлэн байхыг мэдэгдье.

Сургалтын менежер:/А.Энхцэцэг/

Анги удирдсан багш:/

1. Халуурах, тууралт туурах, гүйлгэх, бөөлжих, үлбэгэр байх тохиолдолд Хүүхдээ гэртээ байлган, өрхийн эмчтэйгээ холбогдож, зохих арга хэмжээг авна.

Салхин цэцэг, шар, менингит, сахуу татран, гахайн хавдар, улаан бурхан, хөхүүл ханиад, улаанууд зэрэг хурц халдварт өвчин туссаныг эмч тогтоосон тохиолдолд сургуульд яаралтай мэдэгдэнэ. Хүүхдээ бүрэн эдгэртэл гэртээ байлгана.

10. Гар утас болон бусад электрон хэрэгслүүд

БСШУСЯ –ны сайдын А/43 тоот тушаалаар “Сургууль дээр ухаалаг утас хэрэглэхийг хориглоно” гэсэнтэй хобоотойгоор 1-5-р ангид сурдаг хүүхдэдээ гар утас сургуульд нь өгч явуулахгүй байхыг анхаарна уу. Дунд, ахлах ангийн сурагчид нь онцгой тохиолдолд л бид сурагчийг биедээ гар утас авч явахыг зөвшөөрнө. Дунд ангийнхан гар утсаа хичээл эхлэхээс өмнө унтрааж өөрийн шүүгээнд хийж, хичээл тартал шүүгээндээ хадгална. Урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гар утас ашигласан тохиолдолд гар утсыг нь хураан авч, хичээлийн 1 долоо хоногийн дараа сургуулийн захирлаас зөвшөөрөл авч эцэг, эхэд нь эргүүлэн өгнө. Бүх хураагдсан утсыг сургуулийн захирал хадгална. iPad, CD, зөөврийн комьюнтиер, game boy тоглоом болон бусад үнэтэй эд, хэрэгслийг сургууль дээр авчрахыг хориглоно.

Журмыг зөрчин, гар утас, электрон хэрэгслээ авчирсны улмаас хаях гээх, хулгайд алдах зэрэг гарч болох хохирлыг сургуулийн захиргаа, ажилтан хүлээхгүй болохыг анхаарна уу.

Сурагчдыг чөлөөт цагаар нь нас сэтгэхүйн онцогт тохирсон нэвтрүүлэг, үзвэр үйлчилгээ үзүүлж байх.

Зурагтыг хэт ойр удаан хугацаагаар үзэх нь хараа муудах, нүдний ядаргаанд ордог.

Цахим орчинд кино үзэх /байлдаантай/, тоглоом тоглох, Fb, youtube, messenger зэргийг ашиглахыг хориглоно. Эдгээрт цаг тухайд нь хяналт тавьж байх.

11. Тэмдэглэлт баяр

Бид сурагчдынхаа төрсөн өдрийг анги дээрээ тэмдэглэх явдлыг дэмжинэ. Гэхдээ сургуулийн орчинд төрсөн өдрийн цэнгүүнийг хэт нүсэр, өргөн хүрээтэй байлгахгүй байх тал дээр анхаарах хэрэгтэй. Бусад ангид саад болохгүй байх ба хичээлийн цагаар биш нэмэлт цагаар тэмдэглэх талаас нь зохион байгуулна.

13.1. Тэмдэглэлт баяр зохион байгуулах дүрэм журам

Таны хүүхэд сургууль дээрээ төрсөн өдрөө тэмдэглэхийг хүсэж байгаа бол эдгээр дүрмийг дагаж мөрдөх шаардлагатай. Дүрмийг дагаж мөрдөхгүй бол сургууль дээрээ төрсөн өдрөө тэмдэглэх боломжгүй.

1. Хүүхдийнхээ төрсөн өдрийг сургууль дээр нь тэмдэглэх тухайгаа 1-3 хоногийн өмнө ангийн багшид нь урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсан байх хэрэгтэй.
2. Төрсөн өдрийг үдийн цайны цагаар тэмдэглэх бөгөөд хичээлийн цагаар тэмдэглэх боломжгүй
3. Бялуу, тахианы max, пицца авчрахыг зөвшөөрнө. /Эдгээр нь шинжилгээний бичигтэй байх шаардлагатай /

13.2. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд

Хичээлийн жилүүдэд бүх нийтээр тэмдэглэн өнгөрүүлдэг баяруудыг орууллаа. Цагаан сар, Их эзэн Чингис хааны мэндэлсэн өдөр нь билгийн тоолол харан цаг хугацаагаа товлодог учиртай. Тиймээс цаг тооны бичиг хараахан гараагүй тул аргын тооллоор хэзээ болох нь тодорхойгүй байна.

1. Бүгд найрамдах улс тунхагласан өдөр: 11 дүгээр сарын 26
2. Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтолцоо сэргээсний баярын өдөр: 12 дугаар сарын 29
/Энэ заалтыг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн/
3. Шинэ жил: 1 дүгээр сарын 1
4. Цагаан сар: Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1, 2, 3
5. Олон улсын эмэгтэйчүүдийн өдөр: 3 дугаар сарын 8
6. Их Эзэн Чингис хааны өдөр: Их Эзэн Чингис хаан мэндэлсэн билгийн тооллын өвлийн тэргүүн сарын шинийн 1 */Энэ заалтыг 2012 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хуулиар нэмсэн/*
7. Хүүхдийн баяр: 6 дугаар сарын 1

12. Сурагчдын аялал

Багш эцэг эхчүүд нь сурагчдыг аялалд авч явахаар бол хоорондоо зөвшилцэн сургуулийн захиргаанд мэдэгдэн зөвшөөрөл авна.

Монгол – Од сургууль нь жил бүрийн хавар сургуулиараа “Найрамдал зуслан” явж амардаг билээ. Амарсан хугацааны хичээлийг сургууль зохицуулан нөхөж ордог.

Найрамдал зуслан явахад анхаарах зүйл:

- Найрамдал зуслангийн дотоод дүрэм журмыг баримтална.
- Анги болон бүлгийн багшийн заавар дор сурагчид амралтыг зөв боловсон өнгөрөөнө.
- Дур мэдэн ганцаараа хамт олноосоо салж явахгүй байх
- Бусад найз нөхдийгөө доромжлох, санаатайгаар зодож гэмтээх тохиолдолд тухайн сурагчийн эцэг эхтэй холбогдон гэр рүү нь буцаана.

13. Хүүхдэд чиглэсэн сурх орчин

- Хүүхдийн сонирхолд бүрэн нийцсэн сургалтын орчинг бүрдүүлэх
- Сургууль дээр анги хамт олны халуун дулаан уур амьсгал бүрдүүлэх
- Бусдын сурх арга барил, хэв маягийг хүндэтгэх
- Хүүхдийг хүндрэлтэй асуудал шийдвэрлэх, зөв сонголт хийх, бүтээлч байх болон өөрийгөө илэрхийлэхэд сургах
- Хүүхдийг сэтгэл санаа, оюуны болон нийгмийн хувьд өв тэгш хүн болгохын тулд багаас нь хувь хүний эерэг имижийг бүрдүүлэх
- Эцэг эх, ахмад хүмүүс, хамт олон, үе тэнгийнхэн болон дүү нараа хүндэтгэдэг болгож хүмүүжүүлэх
- Өөрийн хийсэн үйдлийн үр дагаврыг ойлгож хийсэн үйлдэлдээ хариуцлага хүлээж чаддаг болгох
- Чанартай боловсролын программаар хангах

14. Хүүхдээ амжилттай суралцахад нь хэрхэн туслаар

Эцэг эх бүр өөрийн хүү, охиноо нийгэмд бусадтай хөл нийлүүлэн алхах чавдартай, бие хүн болгон төлөвшүүлэхийг зорино. Эцэг эхчүүд өөрийн хүүхэд болон багш, сургуулийн ажилтнуудад тогтмол туслалцаа үзүүлж ажилласнаар бидний зорилго биелэгдэх болно. Үүний тулд дараах зүйлст анхаарал хандуулах хэрэгтэй. Үүнд:

- Хүү, охиноосоо хичээл дээрээ юу сурч мэдсэн болон сургуулийн орчинд ямар онцлог үйл явдал болсон талаар байнга асууж, мэдээлэл солилцож байх.
- Хүү, охин тань тухайн өдрийн хичээл дээр сурлагын амжилт үзүүлсэн, сайн дүн авсан тохиолдолд байнга урамшуулж байх.
- Хүү, охин тань танд ямар нэгэн санал хэлсэн үед багштай нь энэ талаар биечлэн уулзаж, ярилцах. Ингэснээр таны мэдээгүй зүйлийг багш хэлэх, эсвэл сургуулийн багш, ажилтнуудын мэдээгүй зүйлийн талаар та тэдэнд мэдээллэх харилцан ашигтай байх талтай.
- Сургуулийн багш, ажилтнуудтай холбогдон, асуудлыг чөлөөтэй тавьж хэлэлцэж байх. Сургуулийн зүгээс боломжтой бүх асуудлаар тусlamж үзүүлэхэд бэлэн байна.
- Хүү, охиноо хичээлийн цагаас хоцроохгүй байх. Мөн шаардагдах хичээлийн хэрэгслийг хангасан эсэхэд анхаарал тавих
- Хүү, охиноо хичээлийн дараах дугуйланд хамрагдахад дэмжлэг үзүүлэх
- Хүү, охин тань өдөр бүр гэрийн даалгавраа хийсэн эсэхэд хяналт тавин шалгаж, дутуу хийсэн бол даалгаврыг гүйцээн хийлгэх
- Хүү, охин тань хангалттай унтаж амарч байх.

15. Бие даалт, гэрийн даалгавар

Бие даалтын ажлыг үзсэн хичээлээ үргэлжлүүлж ойлгосноо бататгах, шалгах, амжилтаа ахиулах, түвшинг тодорхойлох шаардлагаар ялангуяа дунд ангиас эхлээд сурагчдын биеэ даах, аливааг зохион байгуулах чадвар суулгахын тулд өгдөг. Энэ ажлыг сурагчид цаг хугацаанд нь хүлээлгэн өгсөн байх шаардлагатай тул дүн гарах явцад баримтжуулан бичилт хийнэ.

Бие даалтын ажлаа хугацаанд нь дуусгаж өгөөгүй сурагч дараах таагүй үр дүнд хүрнэ:

- Багш анхааруулга өгч, эсвэл дуусгах үүрэг өгч нэг өдрийн хугацаа өгнө. Хэрэв хийгээгүй бол 0 үнэлгээ өгнө.

- Сурагч 2 дахь удаагаа багшийн даалгавар биелүүлээгүй ирсэн тохиолдолд даалгавраа хийж дуустал хичээлийн дараах дугуйлангаас түдгэлзүүлнэ. Хийж дуусгаагүй тохиолдолд 0 үнэлгээ өгөх болно.
- Хэрэв дахин давтагдвал буюу 3 удаа болоход сургуулийн захиргаанд хэлж, эцэг эхэд мэдээллэнэ.

Энэ байдал байнга давтагдсаар тухайн хичээлээс хоцрогдсон тохиолдолд анги улирах таагүй үр дүнд хүрнэ.

17.1. Гэрийн даалгавар

Багшийн өгсөн гэрийн даалгаврыг хүүхэд танхимын сургалтаас гадуур өөрөө бие даан эсхүл эцэг, эхийн тусламжтайгаар гүйцэтгэсэн байна. Гэрийн даалгавар нь сурч, мэдэх үйл явцын салшгүй нэгэн хэсэг мөн. Гэрийн даалгавраа тогтмол хийх нь амжилттай сайн суралцан, гүн бат мэдлэг эзэмшихийн нэг үндэс суурь болж өгдөг. Гэрийн даалгавар нь заримдаа дэмжигдэж, бас шүүмжлэгддэг бөгөөд даалгавар хийх нь асар их ач холбогдолтой. Учир нь хичээл дээр үзсэнээ бататган ойлгох, сэргээн санах чадварыг хөгжүүлдэг. Зөвхөн ангид бус гэртээ, хаана ч сурах үйл явц байж болохыг ойлгуулдаг. Ангид хичээл дээр хийх ёстой даалгаврыг цаг тухайд нь дуусгаагүй тохиолдолд гэртээ үргэлжүүлэн хийж болох бөгөөд энэ нь гэрийн даалгавар гэхээс илүүтэйгээр ангийн ажлын үргэлжлэл гэж тооцогдоно. Хугацаа: Сурагчдын гэрийн даалгавар хийж дуусгах хугацаа нь харилцан адилгүй. Гэрийн даалгаврыг сурагч бие даан гүйцэтгэх хэрэгтэй. Бусад сурагчдын гэрийн даалгаврыг хуулах, эцэг эх, гэрийн багш сурагчийн өмнөөс гэрийн даалгаврыг нь хийхийг хүлээн зөвшөөрөхгүй.

Бага ангийн сурагчдад богинохон үргэлжилдэг олон даалгавар зохимжтой. Энэ нь бага насын хүүхдийн анхаарал төвлөрөх чадвар богино хугацаанд үргэлжилдэгтэй холбоотой юм. Бага насын хүүхэд аливаа зүйлийг олон дахин заалгаж, давтаж байж сурдаг. Мөн дунд ангиас олон төрлийн хичээл ордог учир даалгаврыг гэрт үргэлжлүүлэн хийх шаардлагатай байдаг.

17.2. Гэрийн даалгавар хийхэд эцэг эх оролцсоноор:

- Хүүхдийн сурах үйл явц, чадварыг хурдан болгодог.
- Эцэг эхийг сургалтын явцад татан оруулдаг.

- Сургалт, боловсролын талаар эцэг эхэд таатай сэтгэгдэл төрүүлдэг.
- Сурах процесс, ахицыг хамт хянах боломж олгодог.
- Эцэг эх гэрийн даалгаварт оролцсоноор сургууль, гэр бүлийн харилцаа гүнзгийрдэг. Гэвч сул тал нь эцэг эх хүүхдийг будлиантуулж, эргэлзээнд хүргэдэг. Учир нь эцэг эхийн арга барил заримдаа буруу байдаг. Мөн хүүхэд ганцаараа хийж чадах юманд эцэг эх оролцсоноос хүүхдийн чадвар, бие даалт нь буурдаг.

17.3. Сурагчдын бие даан гэрийн даалгавар гүйцэтгэх хугацаа:

Анги	Өдөрт
1-р анги	15-20 минут
2-3-р анги	30-45 минут
4-5-р анги	45минутаас - нэг цаг
6-р анги	60 минут орчим
7-р анги	75 минут орчим

17.4. Багшийн үүрэг хариуцлага

- Ангид заасан хичээлээ баталгаажуулж, дараагийн шинэ хичээлийн сэдэвт сурагчийг бэлдэхүйц гэрийн даалгавар байх
- Гэрийн даалгаврын агуулгыг сурагчдад тайлбарлах
- Гэрийн даалгаврыг ямар хэмжээнд хийсэн байх шаардлагатайг сурагчдад ойлгуулсан байх
- Гэрийн даалгаврын биелэлтэд хяналт тавих
- Өгсөн үнэлэлт, дүгнэлтийг сурагчдад буцаан мэдээллэх

17.5. Сурагчийн үүрэг хариуцлага

- Гэрийн даалгаврын талаарх ойлгомжгүй зүйлийг асуух
- Гэрийн даалгаврыг бие даан хийсэн байх, аль болох бага хэмжээгээр эцэг эхээс тусламж авах нь чухал
- Гэрийн даалгаврыг хийхдээ найз нөхдөөсөө хуулбарлахгүй байх
- Гэрийн даалгаврыг ангид хийдэг стандартын дагуу цэвэр нямбай хийж

дуусгасан байх

- Гэрийн даалгаврыг багшийн зааврын дагуу гүйцэтгэж, хураалгах

17.6. Эцэг Эцэг эхийн үүрэг хариуцлага

- Хүүхэд чимээгүй, гэрэлтүүлэгтэй орчинд хичээл хийх
- Даалгавар хийж дуустал нь телевиз, утас, компьютераас хол байлгах. Хажууд нь хөгжилтэй нэвтрүүлэг гарч, компьютер тоглох үед хүүхдийн анхаарал төвлөрөхөд тун хэцүү байх болно.
- Хэрэгцээт зүйлс нь бүрэн байх
- Хүүхдээс хэрэгтэй зүйлийг нь асуух
- Өдөр бүр тогтсон цагт даалгавраа хийж хэвших
- Хүүхэддээ гэрийн даалгавар нь хичээлээ сурх чухал зүйл гэдгийг хэлж өг. Гэрийн даалгаварт та яаж хандах нь хүүхдэд яг тэгж тусна. Гэрийн даалгаварт та эергээр хандаарай.
- Гэрийн даалгавар нь том болоод юунд хэрэгтэйг нь ойлгуулна.
- Хүүхдэд туслахыг хүсвэл шууд хариуг бус , хийх аргыг нь зааж өгөөрэй.
- Хэрэв багш таныг даалгавар хийхэд ямар нэг үүрэгтэй оролц гэвэл та түүнийг хийх ёстой. Багштай хамтарч ажиллавал сургууль, багш, гэр бүл нэг баг гэдгийг хүүхдэд ойлгуулна.
- Хүүхэд гэрийн даалгаврыг ганцаар хийх бол түүнд бүү оролцоорой. Гэрийн даалгавар нь хүүхдийг бие даасан, хараат бус байдал, насан туршдаа тасралтгүй суралцах чадварт сургадаг учраас эцэг эх түүнд дэндуү их оролцвол энэ байдал алдагддаг.
- Хүүхэд гэрийн даалгаврын хэцүү, амар хялбарыг ялгаж ойлгоход тусалж ядраагүй үед нь даалгаврыг хүндээс нь эхлэн хийлгэж байх
- Хүүхэд ядарч мухардалд орвол завсарлага өгч түр хөндийрүүлэх хэрэгтэй.
- Гэрийн даалгавар хийх явцад хүүхдийн амжилтыг үнэлж, шагнаж урамшуулах зэргээр шинэ эрч хүч өгч байгаарай. Ж/нь: Хоолонд орох, парк явах, аялах, үзвэр үзэх, номоор шагнах гэх мэт.

- Гэрээр унших: Гэрийн даалгавраас гадна өдөр бүр ном унших дадлыг сурагч бүрт хэвшүүлэх шаардлагатай.

Гэрийн даалгавар нь хүүхдийн сурлагыг амжилтад хүргэх эерэг хүчтэй үзүүлэлт юм. Хүүхэд дадлагаших, сахилга бат, дэглэмтэй болохоос гадна гэр бүлийн зүгээс хүүхдийнхээ боловсролд түлхүү анхаарал тавьж байгааг илэрхийлнэ. Ингэснээр таны хүүхэд илүү хариуцлагатай болж төлөвших юм.

Гэрийн даалгавар сурагчдыг дараагийн шинэ хичээлийн сэдэвт бэлтгэх, ангид үзсэн зүйлсээ баталгаажуулах, ангид ахиж дуусаагүй ажлуудыг дуусгах явдал юм. Хичээлийн шинэ сэдвээр гэрийн даалгавар өгөхгүй, харин үр дүнтэй байлгах үүднээс сурагчид багшаасаа үнэлэлт, дүгнэлт авсан байх ёстой, эсвэл алдаа оноогоо өөрөө олж мэдэх нь чухал.

16. Дүрэмт хувцас

Монгол - Од сургууль нь сурагчдын зохимжтой хувцаслалтыг эрхэмлэнэ. Суралцагчид нь сургуулийн баталсан дүрэмт хувцас өмсөнө.

18.1. Бага анги /1-5 дугаар анги /

Хөвгүүд:

Үндсэн иж бүрдэл: Пиджак, өмд

Нэмэлт иж бүрдэл: Цамц, зангиа

Охид:

Үндсэн иж бүрдэл: Пиджак, сарафан

Нэмэлт иж бүрдэл: Цамц

Бага ангийн дүрэмт хувцастай зураг

18.2. Дунд анги / 6-8 дугаар анги /

Хөвгүүд:

Үндсэн иж бүрдэл: пиджак, өмд

Нэмэлт иж бүрдэл: цамц, зангиа

Охид:

Үндсэн иж бүрдэл: пиджак, юбка

Нэмэлт иж бүрдэл: цамц, зангиа

Дунд ангийн дүрэмт хувцастай зураг

Эдгээр хослолуудаас бүрдэнэ. Хослолуудыг **ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН НЭР** ХХК дээр очиж захиалгаар хийлгэн худалдан авна.

18.3. Сурагчид дүрэмт хувцсаа өмсөхөөс гадна дараах журмыг даган мөрдөнө.

Үүнд:

- Дүрэмт хувцсыг эмх цэгцтэй, цэвэр нямбай өмссөн байна.
- Дүрэмт хувцсанд өөрчлөлт оруулахгүй бөгөөд шошгон дээр анги нэрээ бичсэн байна.
- Хичээлийн цагаар жинсэн өмд өмсөхийг хориглоно

18.4. Гутал:

- Сургууль дээр биед эвтэйхэн гутал сольж хэвших мөн шалан дээр зураас гаргахгүй байх шаардлагатай.
- Охидын гутал хэт өндөр өсгийтэй байж болохгүй
- Сольж өмсөх гутлыг сургууль дээр орхиод явж байхыг зөвлөж байна

18.5. Үс:

- Сурагчид үсээ даруу, нямбай засуулсан байна. Хэт маягтай үсний засалтыг зөвшөөрөхгүй
- Сурагчид үсээ элдэв өнгөөр /Жишээ нь: ягаан, ногоон... гэх мэт / будсан үсийг хориглоно.
- Үсний зүүлт, боолт нь даруухан дүрэмт хувцастай зохицсон байна.

18.6. Гоёл чимэглэл:

- Хүзүүний зүүлт болох ба тэр нь жижиг байх бөгөөд нүсэр том байхыг зөвшөөрөхгүй
- Бөгж зүүхийг хориглоно.
- Охидууд нэг хос ээмэг зүүхийг зөвшөөрдөг бөгөөд биеийн ил гарах /жишээ нь: хамар, хөмсөг...гэх мэт/ газар чимэг зүүлт зүүхийг хориглоно.
- Охид нүүр, хумс бувахгүй ямар нэг будаг хэрэглэсэн тохиолдолд арилгах шаардлага тавина.
- Охид өнгөгүй лакаар хумсаа будаж болно.

Мөн сурагчид сургуулийн дүрэм журам дагах болон, эрүүл орчинд суралцах үүднээс гадуур гутал, хувцастай сургуульд орохыг хатуу хориглоно. Тиймээс 2 – 8 дугаар ангийн сурагчид В1 давхарт гадуур хувцас, гутлаа солиод анги тахимдаа орно.

17. Биеийн тамирын хувцас

Монгол-Од сургууль нь биеийн тамирын хичээлийн тусгай дүрэмт хувцастай бөгөөд сургуулийн логотой гадуур өмд цамцны хослoluудаас бүрдэнэ. Эдгээр хослoluудыг спортын хувцасны үйлдвэр “Monline” ХХК дээр очиж захиалгаар хийлгэж худалдан авна. Сурагчид нь биеийн тамирын хичээлдээ биеийн тамирын дүрэмт хувцсаа зохих ёсоор заавал өмсөж зориулалтын спортын гуталтай орох хэрэгтэй. Үүнээс гадна доорхи шаардлагыг тавина.

Үүнд:

- Платформ ултай гутал, аяллын пүүз өмсөхийг хориглоно.
- Урт үстэй бол заавал боосон байна.
- Ээмэг, бөгж, зүүлт зэрэг гоёл зүүхгүй байх

Дээр дурдсан шаардлагыг биелүүлээгүй үед биеийн тамирын хичээлд оролцуулахгүйг анхаарна уу.

Тамирын хувцасны зураг

19.1. Биеийн тамирын хичээлд тавигдах шаардлага, тусгай мэдээлэл

Бүх суралцагчдын аюулгүй байдал, ая тухтай нөхцлийг хангах үүднээс сурагчид биеийн тамирын хичээлд бэлтгэлтэй ирэх шаардлагатай. Уг хичээл орох хуваарьтай өдөр сурагчид сольж өмсөх биеийн тамирын хувцастай ирнэ. Эцэг эхчүүд хүүхдийнхээ хувцсанд таних тэмдэг оёх хэрэгтэй. Сурагчид биеийн тамирын хичээлд ирэхдээ дараах зүйлийг сайтар анхаарах хэрэгтэй.

19.2. Тохиромжтой хувцас: будаг гардаггүй спорт гутал, биед эвтэйхэн цамц, өмд (хичээлийн дүрэмт хувцас, даашинз, банзал, жинс нь тохиромжгүй)

19.3. Үнэт эдлэл: Аюулгүй байдлын үүднээс бугуйн цаг, хүзүүний зүүлт, ээмэг, бугуйвч гэх мэт үнэт эдлэл зүүхгүй байх. Эдгээр зүйлсийг гэртээ орхих эсвэл биеийн тамирын хичээлтэй өдөр сурагчдын шүүгээнд хадгалж болно.

19.4. Үс: Урт үстэй сурагчид үсээ боосон байх.

19.5. Өвчин, гэмтэл: Хэрэв таны хүүхэд өвчтэй эсвэл гэмтлийн улмаас хичээлдээ оролцож чадахгүй тохиолдолд эмч, эсвэл эцэг эхээс бичиг ирүүлэхийг шаардана. Жич: Эдгээр шаардлагуудыг хангагүй сурагчид биеийн тамирын багш аюултай гэж үзсэн тохиолдолд хичээл болон бусад спортын үйл ажиллагаанд оролцох боломжгүй.

18. Дунд ангийн суралцагчдын талаарх эцэг эх багшийн харилцах дэвтэр

Дунд ангийн сурагчийн харилцах дэвтрийг эцэг эхчүүд долоо хоног тутам шалгаж байх хэрэгтэй ба харилцаа холбооны хэрэгсэл болгон ашиглах боломжтой юм. Багш нар сурагчийн амжилт дэвшил, алдаа дутагдал гэх мэт зан харилцаа түүнчлэн гэрийн даалгаврын талаар сурагчийн харилцах дэвтэр дээр тэмдэглэл хийх болно.

Хүүхдийнхээ сурагчийн харилцах дэвтрийг байнга шалгаж, санаа зовниж байгаа асуудал, санал болгох зүйлээ бичиж явуулж байгаарай. Сурагчийн харилцах дэвтэр нь зөвхөн гэрийн даалгаврын тэмдэглэл биш бөгөөд гэр ба сургуулийг холбох гол харилцах хэрэгсэл юм.

19. Сургалтын төлбөр

03 сарын 24-с 05 сарын 31

Хуучин сурагчид:

Ирэх жилийн суудал хадгалалт буюу 05 сарын 31-с өмнө^{500 000 төгрөгийг тушаана.}

Шинэ сурагчид:

05 сарын 31-с өмнө ирж анкет болон шалгалтаа өгнө.
06 сарын 01-нд гаргасан өргөдөл. Бид “Хүлээн зөвшөөрсөн” эсвэл “Хүлээгдэж байгаа” талаар эцэг эхчүүдэд хандах болно. Хэрэв зөвшөөрсөн бол эцэг эх нь бүртгүүлэх ажлыг дуусгавар болгож, 06 сарын 15-аас өмнө 500 000 төгрөг төлнө.

06 сарын 01-с 08 сарын 15

Хуучин сурагч:

Ирэх жилийн суудал хадгалалт буюу 08 сарын 15-с өмнө^{500 000 төгрөгийг тушаана.}

Шинэ сурагчид:

08 сарын 15-с өмнө ирж анкет болон шалгалтаа өгнө.
08 сарын 16-нд гаргасан өргөдөл. Бид “Хүлээн зөвшөөрсөн” эсвэл “Хүлээгдэж байгаа” талаар эцэг эхчүүдэд хандах болно. Хэрэв зөвшөөрсөн бол эцэг эх нь бүртгүүлэх ажлыг дуусгавар болгож, 09 сарын 01-ээс өмнө 500 000 төгрөг төлнө.

	Жил		Хагас жил /х2/		Улирал /х2/	
	Хэмжээ	Хугацаа	Хэмжээ	Хугацаа	Хэмжээ	Хугацаа
Цэцэрлэг	2 600 000	Элсэхэд	1 400 000	<input type="radio"/> Элсэхэл <input type="radio"/> 12 сарын 31	750 000	<input type="radio"/> Элсэхэд <input type="radio"/> 10 сарын 31 <input type="radio"/> 12 сарын 31 <input type="radio"/> 3 сарын 31
Сургууль	3 400 000	Элсэхэд	1 800 000	<input type="radio"/> Элсэхэл <input type="radio"/> 12 сарын 31	950 000	<input type="radio"/> Элсэхэд <input type="radio"/> 10 сарын 31 <input type="radio"/> 12 сарын 31 <input type="radio"/> 3 сарын 31
Дугуйлан 1	400 000	Элсэхэд	200 000	<input type="radio"/> Элсэхэд <input type="radio"/> 12 сарын 31	100 000	<input type="radio"/> Элсэхэд <input type="radio"/> 10 сарын 31 <input type="radio"/> 12 сарын 31 <input type="radio"/> 3 сарын 31
Дугуйлан 2	400 000	Элсэхэд	200 000	<input type="radio"/> Элсэхэл <input type="radio"/> 12 сарын 31	100 000	<input type="radio"/> Элсэхэд <input type="radio"/> 10 сарын 31 <input type="radio"/> 12 сарын 31 <input type="radio"/> 3 сарын 31

Шилдэг сурагчийн хөнгөлөлт - 25%

Гэр бүлийн хөнгөлөлт – 25%

20. Хичээлийн дараах дугуйлан буюу сонгон суралцах хичээл

Сургуулиас сурагчдын нөөц бололцоо, авьяас сонирхолыг нээж хөгжүүлэх зорилгоор, урлаг болон спортын төрөл бүрийн дугуйлангуудыг санал болгодог. Дугуйлангуудад аль болох олон хүүхэд хамруулахыг зорьдог. Дугуйланд хамрагдсан ирцийн бүртгэл явагдана.

1-8-р ангиудад дараах дугуйлангууд орох болно.

1 ба 2-р анги

Чөлөөт дугуйлан /Долоо хоногт 2 удаа/

- Шатар
- Бүжиг
- Таеквонда
- Англи хэлний ярианы клуб
- Ширээний теннис
- Зураг
-

Төлбөртэй дугуйлан /Долоо хоногт 2 удаа/

- Төгөлдөр хуур

3 ба 8-р анги

Чөлөөт дугуйлан /Долоо хоногт 2 удаа/

- Шатар
- Бүжиг
- Таеквонда
- Англи хэлний ярианы клуб
- Ширээний теннис
- Хөлбөмбөг
- Сагсан бамбөг

Төлбөртэй дугуйлан /Долоо хоногт 2 удаа/

- Төгөлдөр хуур
- Бадминтон
- Франц хэл
- Хятад хэл

21. Сурагчийн зөвлөл

23.1. Эрхэм зорилго: Сурагчийн зөвлөл нь нийт анги бүлгийг хамарсан ил тод нээлттэй үйл ажиллагаа явуулж, суралцагчдын эрх ашгийг хамгаалан тэдний өмнө тулгамдсан асуудлыг илрүүлж, шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх ба сурагчийн зөвлөлийн гаргасан шийдвэр нийт суралцагчдын эрх ашигт нийцэж, тэднийг нийгмийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах чадвартай бие хүн болгон төлөвшүүлэхэд зорино.

23.2. Үйл ажиллагааны үндсэн чиглэл: Сурагчийн зөвлөл нь бусдаас суралцан өөрийгөө хөгжүүлж, амжилттай суралцах хүсэл тэмүүлэлтэй, соёлч боловсон харилцаатай, нинжин сэтгэлтэй хувь хүнийг төлөвшүүлэхэд чиглэн, уулзалт яриа зохион байгуулах сайн дурын аян өрнүүлж, ухуулан сурталчилах самбар гаргах, хууль дүрмийг сахин биелүүлж, эрх – эрх чөлөө, үүрэг хариуцлагаа ухамсарлаж сурахад нөлөөлнө.

23.3. Сурагчийн зөвлөлийн бүрэлдэхүүн

- Сурагчийн зөвлөлийн дарга /Бүх гишүүд хэлэлцэн сонгоно/
- Нарийн бичгийн дарга
- Бусад гишүүд
- Зөвлөх багш

23.4. Зөвлөх багш дараах үүрэгтэй ажиллана:

- Сурагчийн зөвлөлийн үндсэн ажлыг чиглүүлж, зааварлана.
- Санхүүгийн бичиг баримт хөтлөх, цуглаан зохион байгуулах зэрэг ажилд тусална.

24. Сурагчдын автобусны үйлчилгээ

Монгол-Од сургууль нь сурагчдад үйлчлэх өөрийн гэсэн автобустай. Автобусны үйлчилгээ нь сургалтын төлбөрөөс гадна төлбөртэй болохыг анхаараарай. Эцэг эхчүүд та хүүхдээ автобусаны үйлчилгээнд хамрагдахаар бол дараах зүйлсийг анхаарна уу!

- Сургуулийн захиргаанд мэдэгдэж гэрээ хийх ба төлбөрийн тооцоогоо урьдчилан хийсэн байна.
- Тогтоосон цаг хугацаанд хүүхдээ бэлэн байлгах
- Таны хүүхэд ямар нэг шалтгааны улмаас хичээлдээ явахгүй тохиолдолд жолоочид урьдчилан мэдэгдэнэ.
- Сургуульдаа ирэх явах үед хүүхдээ жолоочид хүлээлгэн өгөх ба хүлээж авна.
- Автобусаар үйлчлүүлэгчид нь мөнгө төгрөг, утас, тоглоом ил авч явж гээсэн тохиолдолд автобусны жолооч хариуцахгүй
- Сурагч сургуулийн автобусаар ЗӨВХӨН гэр, сургууль болон буухаар зөвшөөрөгдсөн газраа бууна. **ӨӨР АВТОБУС, МАШИНААР ЯВДАГ НАЙЗЫГАА ГЭРТЭЭ АВААЧИХААР АВТОБУСАНД ХАМТ СУУЛГАХЫГ ЗӨВШӨӨРӨХГҮЙ.**
- Автобусны үйлчилгээтэй холбоотой аливаа асуудлыг сургалтын албатай холбогдож шийдвэрлэнэ Автобусны жолоочид шууд хандахгүй.
- Хэрэв сурагч автобусыг байнга хүлээлгэж хүндрэл учруулдаг бол энэ байдлыг захиргаанд мэдэгдэнэ. Дахин давтагдсаар байвал эцэг эх хүүхдээ зөөх өөр арга замыг олж зохицуулах шаардлагатай.

Бидний зүгээс автобусны дотор, гадна талын цэвэр цэмцгэр, тав тух, аюулгүйн байдал дээр анхаарал тавин ажиллах болно.

24.1. Автобусны чиглэлүүд:

Чиглэл заасан зураг оруулах

24.2. Сургуулийн автобусны ирэх, явах цаг



Сургуулийн автобусны ирэх, явах цаг

- Өглөө 8:20 цагт автобус сургууль дээр ирнэ.
- 16:00-16:15 цагаар онд бих автобус

25. Номын сан

25.1. Сургуулийн номын сангийн зорилго:

Хүүхдийн унших, сурах хүсэл эрмэлзлийг дэмжих. Сурагчдын амжилттай сурч, амьдралынхаа турш сурах хүсэл эрмэлзлэлийг нь хэвшүүлэхэд шаардагдагдах бололцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Сурагчид долоо хоногт нэг удаа хуваарийн дагуу номын сангаар үйлчлүүлнэ. Номын сангаас авсан номыг хугацаанд нь буцаан өгснөөр дараагийн сурагч хэрэглэх боломжийг хангана.

25.2. Номын сангийн журам

- Номын санд идэж уух зүйлс авч орохгүй.
- Ангийн багш болон номын санч шаардсан тохиолдолд сурагчид хичээлийн хэрэгслээ (ном, дэвтэр гэх мэт) авч орж болно.
- Номын санд авч ирсэн зүйлсээ сурагч өөрөө хариуцах ба номын сангийн зүгээс алдагдсан, гээгдсэн зүйлийн хариуцлагыг хүлээхгүй.
- Номын сангаар үйлчлүүлэхдээ бусдыг хүндэтгэн, дуу чимээ гаргахгүй ба бусдад чимээгүй ажиллах орчинг бүрдүүлнэ.
- Сурагчид номын сангаар үйлчлүүлэхдээ сахилга баттай, хариуцлагатай байх шаардлагатай. Биеэ зөв авч явж чадаагүй тохиолдолд номын сангаар үйлчлүүлэх эрхийг хасах хүртэл сахилга батын арга хэмжээ авна.
- Зээллэсэн номоо эргүүлэн өгөх хугацааг компьютерээр хянах ба энэ талаар маргах боломжгүй. Сурагчид асуух зүйл гарсан тохиолдолд номын санчид хандаж болно.

Зээллэсэн номоо гэмтээж, үрэгдүүлсэн тохиолдолд зохих хохирлыг барагдуулах үүрэгтэй.

- Номын сангийн дүрмийг зөрчсөн сурагчийг номын сангаас гаргахыг шаардах эрхийг номын санч эдэлнэ.

26. Хичээлийн хэрэгсэл ба ном

Ном сурх бичгийг сургуулиас хангана. Ном сурх бичиг нь сургуулийн өмч хөрөнгө бөгөөд нямбай ашиглаад жилийн эцэст буцаан өгнө. Номоо хаяж гээгдүүлсэн тохиолдолд сургуульд үнийн дунг буцаан төлнө. Мөн нэмэлт шаардлагатай номыг сурагчид өөрсдөө худалдан авна.

27. Сурагчдын өдрийн хоолны цэс

Манай сургууль нь сурагчдад өдрийн гурван хоолтой бөгөөд өдөр тус бүр долоо хоногоор хоолны цэс өөр өөр байдаг. Үүнийг ахлах тогооч хариуцан эцэг эхэд хоолны цэсийг долоо хоног бүрээр самбарт байрлуулан мэдээллэдэг.

Батлав: Сургалтын менежер /А. Энхцэцэг/

Цэс боловсруулсан: Ахлах тогооч /Л. Оюунбилэг/



МОНГОЛ ОД СУРГУУЛИЙН ХООЛНЫ ЦЭС

..... оны ... сарын-ны өдөр хүртэл

ГАРИГ	Хугацаа	Хоолны нэр
ДАВАА	Өглөө	- Сүүтэй будаа
	Өдөр	- Ногоотой шөл - Будаатай хуурга, хачиртай - Нэрсний жүүс
	Орой	- Печень - Цай

МЯГМАР	Өглөө	- Бoorцог - Цай
	Өдөр	- Бууцайтай гурилтай шөл - Нарийн махан хуурга, мөөгний сүмстэй - Чацаргана жүүс
	Орой	- Шар будаатай сүү
ЛХАГВА	Өглөө	- Кекс - Бор цай
	Өдөр	- Зутан шөл - Гоймонтой хуурга, хачиртай - Аньс жүүс
	Орой	- Аарц
ПУРЭВ	Өглөө	- Сүүтэй будаа
	Өдөр	- Бөөрөнхий махтай, далайн байцайтай ногоотой шөл - Холимог хуурга, хаичртай
	Орой	- Цайны боов - Сүүтэй цай
БААСАН	Өглөө	- Варентай талх - Цай
	Өдөр	- Овьёстай ногоотой шөл - Пирошки, хачиртай - Зөгийн балтай ус
	Орой	- Тараг

28. Кино үзвэрийн өрөө ашиглах журам

Кино үзвэрийн өрөөнд орохдоо анги тус бүр хуваарийн дагуу орж хичээлийн холбогдолтой кино, видео бичлэгүүдийг үзнэ. Үүнд:

- Хог хаягдал хаяхгүй байх
- Техник хэрэгсэл, эд хогшлыг гэмтээхгүй байх
- Чимээ шуугиан гаргахгүй эмх замбараатай байх

- Узвэрийн өрөөнөөс гарахдаа тухайн хариуцагч багш дараагийн ангид хүлээлгэн өгнө.

29. Ширээний тенисний өрөө ашиглах журам

Ширээний тенисийг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж багш сурагчид ээлжлэн тоглоно. Тоглоход хэрэглэгдэх багаж хэрэгслийг тухайн тоглогч нар хариуцан эвдэж гэмтээхгүйгээр тоглож, үүдний жижүүрт хүлээлгэн өгнө. Хэрэв эвдэж гэмтээсэн тохиолдолд тухайн тоглогч төлөх болно

30. Компьютерийн өрөө ашиглах журам

Компьютерийн өрөөнд сурагчид хичээллэхдээ техник хэрэгсэлтэй ажиллахдаа зөвхөн багшийн зааврын дагуу ажиллана/Компьютерийн багш тухайн өрөөний техник хэрэгсэл, эд хогшлыг хариуцана/.

- Хичээллэж дуусаад компьютерийг заавал унтрааж гарна.
- Компьютерийн дотор байгаа программ болон файлуудыг устгахгүй.
- Сурагчийн буруутай үйлдлээс болж эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд тухайн сурагч хариуцаж төлбөрийг барагдуулна.

31. Сурагчийн шүүгээ ашиглах

1 дүгээр ангийн сурагчид гадуур хувцас, ном хадгалах зорилгоор сургуулиас шүүгээ ашигладаг бол 2-8 дугаар ангийн сурагчид зөвхөн ном, хичээлтэй холбоотой хэрэглэгдэхүүн хадгалах зорилгоор ашиглана.

- Θөрийн шүүгээндээ их хэмжээний мөнгө, үнэтэй зүйлс болон үнэт эдлэл авч ирж хадаглахыг хориглоно.
- Авч ирээд алсан тохиолдолд сургууль хариуцахгүй болохыг анхаарна уу!
- Эмх цэгцтэй, хаягтай байлгана.
 - Шүүгээгээ эвдэж гэмтээсэн тохиолдолд засах буюу төлбөрийг төлөх, сольж хэвийн байдалд оруулна.

32. Өвдөх

Хичээлийн үеэр таны хүүхэд өвдөж, халуурсан тохиолдолд эцэг эхэд утсаар мэдэгдэнэ. Ингэж мэдэгдсэн тохиолдолд аль болох хүүхдээ хурдан ирж авах шаардлагатай.

Хүүхэд өвдсөн тохиолдолд бусад сурагчдыг өвчлүүлэхээс урьдчилан сэргийлж тухайн хүүхдийг ангиас тусгаарлана.

Мөн дараах зүйлсийг анхааруулж байна:

1. Халуурах, тууралт туурах, гүйлгэх, бөөлжих, үлбэгэр байх тохиолдолд Хүүхдээ гэртээ байлган, өрхийн эмчтэйгээ холбогдож, зохих арга хэмжээг авна.

Салхин цэцэг, шар, менингит, сахуу татран, гахайн хавдар, улаан бурхан, хөхүүл ханиад, улаанууд зэрэг хурц халдварт өвчин туссаныг эмч тогтоосон тохиолдолд сургуульд яаралтай мэдэгдэнэ. Хүүхдээ бүрэн эдгэртэл гэртээ байлгана.

33. Эмийн хэрэглээ

Таны хүүхэд өдөр эм уух шаардлагатай бол дараах журмыг мөрдөнө:

1. Эм уух зөвшөөрлийг бичгээр ирүүлсэн байна. (Анкетийг сургалтын албанаас авах боломжтой)
2. Эмийг өдөр бүр даванд хийн, уух тунгийн хамт сургалтын албанда авчирч өгнө. Уулгасны дараа савыг буцаан өгч явуулна.
3. Эмийн савны гадна тал дээр хүүхдийнхээ нэр, анги, эм уух цаг, эмийг хөргөх хэрэгтэй эсэхийг бичиж наасан байна.

Бидний хамтын ажиллагаа таны хүүхдэд зохих ёсны анхаарал халамж үзүүлэхэд чухал ач холбогдолтой билээ.

34. Яаралтай үед эцэг эхтэй холбоо барих

Сургуулиас хүүхдийн эцэг эх болон хууль ёсны асран хамгаалагчтай шаардлагатай үед холбоо барина. Тиймээс эцэг эхчүүд бидэнд байнгын ажиллагаатай байдаг утасны дугаарыг бүртгүүлсэн байна. Холбоо барих утас өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаар сургалтын албанда мэдээллэж байх үүрэгтэй. Яаралтай үед сургалтын албанаас сургчийн гэр лүү утасдаж тусална.

35. Хичээлээс гадуурх нэмэлт цаг, таралт

1 – 5- р ангийн үндсэн хичээл 12:30 - 13:00 цагийн хооронд дуусна. 13:30 – 17:30 цагийн хооронд дугуйлантай сурагчид дугуйландаа хичээллэж үлдсэн сурагчид ангидаа анги удирдсан багштай хамт ажиллана. Энэ цагаар сурагчид амрах, ном унших, минутаар

унших, чээж бичиг хийх, шүлэг чээжлэх, шатар, даам тоглох, ойлгосноо ярих, зэрэг нэмэлт ажлуудаас хийх боломжтой ба гэрийн даалгавраа хийнэ.

Даваа – Пүрэв гарагт та хүүхдээ 17:30 – 18:30 цагаас тухайн өдрийн жижүүр багшаас хүлээн авна. Эцэг эхчүүд хүүхдээ сургуулиас нь авахдаа өөрийн биеэр болон эмээ өвөө, ах эгч нар нь ирж авна. Танихгүй болон эцэг эх нь зөвшөөрөөгүй хүнд сурагчийг өгч явуулахгүй болохыг анхаарна уу! Жич: Баасан гарагт багш нар сургуулийн дотоод ажилтай тул 14:30-аас хичээл тарна.

Сурагчийг хичээл тарсны дараа хэн ирж хэдэн цагт авах талаар эцэг эхчүүд анги удирдсан багшийн судалгааг бөглөж гарын үсэг зурж баталгаажуулна.

Дунд ангийн сурагчид хичээл тарсны дараа ганцаараа явахаар бол гэртээ очоод ангийн багшид эргэж мэдэгдэнэ. Тухайн сурагч зам хөндлөн гарч явахаар бол гэрлэн дохио, цагаан шугамаар гарч явахыг багш, эцэг эхчүүд байнга сануулга өгч байх хэрэгтэй. Байгалийн онц аюултай үзэгдэл болж байгаа үед, мөн улирал цаг үеийн байдлаас болж оройтсон тохиолдолд сурагчийг ганцааранг нь явуулахгүй тул эцэг эхчүүд та бүхэн өөрийн биеэр ирж сургуулиас авч байгарай.

Хичээл тарснаас хойш сурагчдад ямар нэгэн зөрчил гэмтэл учирсан тохиолдолд сургууль болон багш хариуцахгүй.

36. Хүндэт эцэг эхчүүдээ!

Бид Монгол-Од сургуулийн үйл ажиллагааны талаар та бүхэнтэй олон арга замаар холбогддог билээ. Та бүхэн өдөр бүр манай сургуулийн (www.mongol-od.mn) вэбсайт болон **Монгол од / Америк Монголын хамтарсан цогцолбор сургууль** / fb хуудсаар зочилж шинэ мэдээ, мэдээллийг авч болно. Энэхүү эцэг эхчүүд та бүхэнд зориулсан зөвлөмж гарын авлага нь Монгол-Од сургуулийн үйл ажиллагааг таниулах нэг арга зам юм. Энэ гарын авлагад хамгийн чухал мэдээллүүдийг багтаасан бөгөөд эдгээр нь таны цаашдын үйл ажиллагаанд хэрэг болно гэдэгт найдаж байна. Бид сурагчиддаа хэвлэмэл хувийг тараах бөгөөд сургуулийн вэб сайтаас энэхүү гарын авлагыг цахим хэлбэрээр харах боломжтой. Бид гарын авлагад ороогүй мэдээллийн талаарх санал хүсэлтийг дуртайяа хүлээн авах болно. Та бүхний санал хүсэлтийг доорх хаягаар авах боломжтой. info@mongol-od.mn Эцэг эхийн гарын авлагыг уншиж танилцсан та бүхэнд баярлалаа.

Эцэг эхийн гарын авлагыг уншиж танилцсанаа гэрчилж гарын үсэг зурав.

Эцэг эхийн гарын үсэг:.....